



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/168/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган 2021 он	Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	Error! Bookmark not defined.

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.02.09 № 30
танай _____-ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.БҮРЭНТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020061

Үүрэг, хариуцлага

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,672,079.70	15,697,848.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	4,000,000.00
3121	Төгрөг	-	4,000,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	4,000,000.00
33	АВЛАГА	460,000.00	1,542,828.85
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,542,828.85
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	460,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	10,212,079.70	10,155,019.70
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	678,900.00
354	Хангамжийн материал	10,212,079.70	9,476,119.70
35420	Аж ахуйн материал	10,212,079.70	9,476,119.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	278,741,562.15	299,274,021.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	278,741,562.15	299,274,021.29
392	Биет хөрөнгө	268,412,282.15	288,823,869.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	236,311,280.00	236,311,280.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,161,115.24)	(18,322,230.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,000,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,000,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,364,750.00	163,063,050.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(78,686,248.24)	(93,918,152.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,374,103.00	14,194,103.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,790,487.37)	(12,504,180.03)
393	Биет бус хөрөнгө	10,329,280.00	10,450,151.67
39301	Програм хангамж	303,180.00	503,180.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(79,128.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,026,100.00	10,026,100.00

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>289,413,641.85</u>	<u>314,971,869.84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,202,674.00</u>	<u>1,270,533.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,202,674.00	1,270,533.00
413	Өглөг	1,742,674.00	1,270,533.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,270,533.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,742,674.00	-
414	Урьдчилж орсон орлого	460,000.00	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	460,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>287,210,967.85</u>	<u>313,701,336.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	287,210,967.85	313,701,336.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	130,294,986.00	130,294,986.00
51101	Өмч: - төрийн	130,294,986.00	130,294,986.00
512	Хуримтлагдсан үр дүн	(77,301,971.49)	(50,811,602.50)
51210	Өмнөх үеийн үр дүн	(77,301,971.49)	(77,301,971.49)
51220	Тайлант үеийн үр дүн	-	26,490,368.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,217,953.34	234,217,953.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>289,413,641.85</u>	<u>314,971,869.84</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	244,019,680.00	274,888,960.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,172,980.00	60,755,760.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,172,980.00	60,755,760.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,172,980.00	57,730,760.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,172,980.00	52,279,560.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,451,200.00
120009	Бусад орлого	-	3,025,000.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	208,846,700.00	214,133,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	202,114,000.00	211,533,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,214,000.00	211,533,200.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	900,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,200,000.00	2,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,600,000.00	2,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	600,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,532,700.00	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,532,700.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	266,994,505.06	247,626,291.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	266,994,505.06	247,626,291.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	207,724,602.06	240,977,055.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126,392,574.00	143,922,137.31
210101	Үндсэн цалин	94,079,374.00	98,370,875.27
210102	Нэмэгдэл	28,155,200.00	41,530,358.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,158,000.00	4,020,904.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,783,421.00	19,073,137.36
210201	Тэтгэврийн даатгал	10,727,321.00	13,391,065.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,264,000.00	1,413,827.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,011,200.00	1,131,060.32
210204	Ажилгүйдлийн даатгал	252,800.00	261,559.99
210205	Эрүүл мэндийн даатгал	2,528,100.00	2,875,623.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,516,774.00	17,362,846.00
210301	Гэрэл, цахилгаан	462,473.00	498,296.00
210302	Түлш, халаалт	14,893,581.00	15,210,480.00
210303	Цэвэр, бохир ус	1,160,720.00	1,654,070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,401,028.00	10,381,946.00
210401	Бичиг хэрэг	1,383,550.00	2,218,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,847,700.00	4,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	795,978.00	1,084,036.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	373,800.00	211,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	802,650.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,865,460.00
2105	Нормативт зардал	-	951,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	951,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,029,100.00	8,462,793.00
210604	Урсгал засвар	2,029,100.00	8,462,793.00
2107	Томилолт, зочны зардал	8,923,287.00	7,972,800.00
210702	Дотоод албан томилолт	8,923,287.00	7,972,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	990,295.00	360,055.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	99,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	72,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	114,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,325.00	46,765.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	-
210807	Газрын төлбөр	15,000.00	15,390.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	659,970.00	12,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,688,123.06	32,489,540.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,685,950.00	5,909,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,500.00	1,394,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,451,673.06	25,185,840.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,269,903.00	6,649,235.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,839,800.00	2,600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,639,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	2,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,172,980.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,172,980.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	257,123.00	4,049,235.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	257,123.00	4,049,235.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(22,974,825.06)	27,262,668.99
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,107,013.94	772,300.00

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,107,013.94	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	772,300.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,107,013.94)	(772,300.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(24,081,839.00)</u>	<u>26,490,368.99</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>244,019,680.00</u>	<u>271,412,760.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,172,980.00	57,279,560.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,172,980.00	57,279,560.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,172,980.00	56,279,560.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,172,980.00	52,279,560.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,000,000.00
120009	Бусад орлого	-	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	208,846,700.00	214,133,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	202,114,000.00	211,533,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,214,000.00	211,533,200.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	900,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,200,000.00	2,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,600,000.00	2,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	600,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,532,700.00	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,532,700.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>244,019,680.00</u>	<u>223,719,460.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	244,019,680.00	223,719,460.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	184,749,777.00	217,070,224.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126,375,495.00	143,922,137.31

210101	Үндсэн цалин	94,062,295.00	98,370,875.27
210102	Нэмэгдэл	28,155,200.00	41,530,358.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,158,000.00	4,020,904.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,800,500.00	19,345,433.21
210201	Тэтгэврийн даатгал	10,744,400.00	13,663,361.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,264,000.00	1,413,827.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,011,200.00	1,131,060.32
210204	Ажилгүйдлийн даатгал	252,800.00	261,559.99
210205	Эрүүл мэндийн даатгал	2,528,100.00	2,875,623.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,774,100.00	19,105,520.00
210301	Гэрэл, цахилгаан	462,473.00	498,296.00
210302	Түлш, халаалт	13,150,907.00	16,953,154.00
210303	Цэвэр, бохир ус	1,160,720.00	1,654,070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,102,900.00	8,835,986.00
210401	Бичиг хэрэг	720,496.00	1,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,200,000.00	4,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	795,978.00	1,084,036.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	386,426.00	333,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,618,800.00
2105	Нормативт зардал	-	1,999,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	999,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.00	8,634,793.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	35,000.00
210604	Урсгал засвар	3,200,000.00	8,599,793.00
2107	Томилолт, зочны зардал	8,923,287.00	7,972,800.00
210702	Дотоод албан томилолт	8,923,287.00	7,972,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	990,295.00	1,032,155.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	72,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	-	114,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,325.00	46,765.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	-
210807	Газрын төлбөр	15,000.00	15,390.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	659,970.00	384,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,583,200.00	6,221,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,032,700.00	4,581,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,500.00	1,640,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,269,903.00	6,649,235.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,839,800.00	2,600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,639,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	2,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,172,980.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,172,980.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	257,123.00	4,049,235.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	257,123.00	4,049,235.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	47,693,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	43,693,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	43,693,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	43,693,300.00
222001	Тоног төхөөрөмж	-	43,693,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(43,693,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	4,000,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	-------	---

C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(53,220,132.49)		311,292,806.85
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(53,220,132.49)	-	311,292,806.85
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(24,081,839.00)		(24,081,839.00)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(77,301,971.49)	-	287,210,967.85
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(77,301,971.49)	-	287,210,967.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(77,301,971.49)	-	287,210,967.85
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	26,490,368.99		26,490,368.99
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,294,986.00	234,217,953.34	(50,811,602.50)	-	313,701,336.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөө/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	201214000.00	208589577.00	261533200.00	259763524.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	201214000.00	208589577.00	261533200.00	216070224.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177974200.00	184749777.00	260933200.00	215470224.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126404900.00	126375495.00	145350200.00	143922137.31
210101	Үндсэн цалин	94091700.00	94062295.00	102674200.00	98370875.27
210102	Нэмэгдэл	28155200.00	28155200.00	38518000.00	41530358.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4158000.00	4158000.00	4158000.00	4020904.00

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15800500.00	15800500.00	19622300.00	19345433.21
210201	Тэтгэврийн даатгал	10744400.00	10744400.00	13808300.00	13663361.56
210202	Тэтгэмжийн даатгал	1264000.00	1264000.00	1453500.00	1413827.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1011200.00	1011200.00	1162800.00	1131060.32
210204	Ажилгүйдлийн даатгал	252800.00	252800.00	290700.00	261559.99
210205	Эрүүл мэндийн даатгал	2528100.00	2528100.00	2907000.00	2875623.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14774100.00	14774100.00	19110500.00	19105520.00
210301	Гэрэл, цахилгаан	456000.00	462473.00	501600.00	498296.00
210302	Түлш, халаалт	13410500.00	13150907.00	17610500.00	16953154.00
210303	Цэвэр, бохир ус	907600.00	1160720.00	998400.00	1654070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5102900.00	5102900.00	8837000.00	8835986.00
210401	Бичиг хэрэг	800000.00	720496.00	1600000.00	1600000.00
210402	Тээвэр, шатахуун	3200000.00	3200000.00	4200000.00	4200000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	795,978.00	1,085,000.00	1,084,036.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	302,900.00	386,426.00	333,200.00	333,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	1,618,800.00	1,618,800.00
2105	Нормативт зардал	-	-	2,000,000.00	1,999,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	1,000,000.00	999,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.00	3,200,000.00	49,800,000.00	7,034,793.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-	42,000,000.00	35,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	800,000.00	-
210604	Урсгал засвар	3,200,000.00	3,200,000.00	7,000,000.00	6,999,793.00
2107	Томилолт, зочны зардал	8,923,300.00	8,923,287.00	8,000,000.00	7,972,800.00
210702	Дотоод албан томилолт	8,923,300.00	8,923,287.00	8,000,000.00	7,972,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,218,000.00	990,295.00	1,213,200.00	1,032,155.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	400,000.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	72,000.00	72,000.00	72,000.00	72,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	121,000.00	-	120,000.00	114,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	93,325.00	42,200.00	46,765.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	-	25,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00	150,000.00	-
210807	Газрын төлбөр	20,000.00	15,000.00	20,000.00	15,390.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00			
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	660,000.00	659,970.00	384,000.00	384,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,550,500.00	9,583,200.00	7,000,000.00	6,221,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	9,032,700.00	5,000,000.00	4,581,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,500.00	550,500.00	2,000,000.00	1,640,100.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,239,800.00	23,839,800.00	600,000.00	600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,239,800.00	23,839,800.00	600,000.00	600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,639,800.00	22,639,800.00	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	1,200,000.00	600,000.00	600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	43,693,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	-	43,693,300.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	43,693,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	201,214,000.00	237,286,980.00	261,533,200.00	267,812,760.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	201,214,000.00	202,114,000.00	211,533,200.00	211,533,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	201,214,000.00	201,214,000.00	211,533,200.00	211,533,200.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	900,000.00	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	35,172,980.00	50,000,000.00	56,279,560.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,172,980.00	50,000,000.00	52,279,560.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	4,000,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	4,000,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	-	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	-	12.00	11.00
620001	Удирдах ажилтан	1.00	-	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	-	7.00	6.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	-	4.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.00	-	12.00	11.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7.00	-	7.00	6.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	-	5.00	5.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	3,600,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,600,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,600,000.00
210604	Урсгал засвар	-	1,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,000,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,600,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,600,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ц.Бүрэнтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 29-өөс 2021 оны 02 дугаар сарын 03-ны “Булган аймаг дахь Төрийн аудитын газар”-ын А.Сувдаа хариуцаж, үе шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлэв.

Булган аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарыг хангахад стандартчилал, хэмжил зүйн бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлнэ” зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх
- Хэмжил зүйн тухай хуулийг хэрэгжүүлэн, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хангах
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.8, Засгийн газрын 2016 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах
- Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тасралтгүй явуулах
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах

- Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах
- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах
- Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх
- Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах
- Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хууль
- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай хууль
- Байгууллагын ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт /Хэлтсийн даргын 2020 оны А/13, А/19 дугаар тушаалаар/
- Стандарт хэмжил зүйн газрын “Хөдөлмөрийн дотоод журам” /2020 оны А/182 дугаар тушаал/

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шүүхийн тамгын газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Тайлант хугацаанд тус байгууллагад Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна. Уг Стандарт, хэмжил зүйн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний багаас нийт 24 асуудлын хүрээнд зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн дагуу биелэлтийг 97 хувьтай тооцон 2020 оны сүүлээр хүргүүлэн ажиллажээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “4966.6 мянган төгрөг” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 117392.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2347.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24405.8 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар

өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	4000.0	4000.0
Авлага	460.0	1542.8	1082.8
Урьдчилгаа			
Бараа материал	10212.1	10155.0	-57.1
Үндсэн хөрөнгө	278741.6	299274.0	20532.5
Нийт хөрөнгө	289413.6	314971.9	25558.2
Өр төлбөр	2202.6	1270.5	-932.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	287210.9	313769.8	26558.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	289413.6	314971.9	25558.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4000.0 мянган төгрөг буюу мөнгөн хөрөнгийг ахмадын санд төвлөрүүлсэн байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 460.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1542.8 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10155.0 мянган төгрөг болж 57.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалд 8029.9 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, 2025.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө рүү шилжүүлэн, 4875.5 мянган төгрөгийн зарцуулалт хийснээс шалтгаалжээ.

Тайлант хугацааны эцэст худалдан авалтаар материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 299274.0 мянган төгрөг болж 20532.5 мянган төгрөгөөр өссөн нь 43693.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 4196.0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 1728.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй бөгөөд, акталсан 14000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Тайлант хугацаанд бараа материалын дансанд бүртгэлтэй 200.0 мянган төгрөгийн архивын программыг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн авснаар биет бус хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1270.5 мянган төгрөг болж 932.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны түлш халаалтын өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр үүсээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд **ХАОАТ-ийг хөнгөлөлт, чөлөөлөлтөөс үүссэн** 1270.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 313769.8 мянган төгрөг болж 26558.8 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн үйл ажиллагааны орлогоос 52279.6 мянган төгрөгийн санхүүжилт орсноос шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 30869.2 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан татварын бус орлого, урсгал үйл ажиллагааны орлого байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдсэн, удаан жилийн нэмэгдэл олгох болсонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 19436.7 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, эд хогшил, урсгал засварын зардлууд байна. Энэ нь тайланд онд удаан жилийн нэмэгдэл олгосон, үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой засвар хийсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга нь байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 347516.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 347516.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 85983.0 мянган төгрөгөөр бууруулж 261533.2 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай сантехник, барилгын засварт 90000.0 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл бэлтгэхэд зориулж 35000.0 мянган төгрөгөөр төсөвлөж хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 36 арга хэмжээг санхүүжүүлэхээр 261533.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 211533.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 50000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 211533.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 52279.6 мянган төгрөг, нийт 263812.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 223719.5 мянган төгрөгийг зарцуулж 4049.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 259763.5 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1428.1, НДШ-ийн зардлыг 276.9, байр ашиглалтын зардлыг 4.9 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 18 арга хэмжээ 4049.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2600.0 мянга, акталсан хөрөнгийг сэлбэгээр борлуулснаас бий болсон нэмэлт орлого 1000.0 мянга, нийт 3600.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал засварт 1600.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 2000.0 мянга нийт 3600.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 393.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1577.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 5585.2 мянган төгрөгийн 7 зөвлөмжийн хэрэгжилт 89.3 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	393.1	1	393.1	0	0	0
Албан шаардлага	1	1577.4	1	1577.4	0	0	0
Зөвлөмж	7	5585.2	6	4982.2	1	600	10.7
Нийт дүн	9	7555.7	8	6955.7	1	600	7.9

Хэрэгжүүлээгүй 600.0 мянган төгрөгийн зөвлөмж давтан гарсан тул албан шаардлага хүргүүлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 60691.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 52317.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 4000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 4374.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн урьдчилгаанд олгосон 1140.0 мянган төгрөгийн авлагыг 9 дүгээр сард бүрэн барагдуулсан.
2. Томилолтын 3520.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын хөтлөлт дутууг бүрэн бүрдүүлсэн
3. Үндсэн хөрөнгө болох цахилгаан эрчим хүч хэмжих зөөврийн хэмжүүрийн урьдчилгаанд 40000.0 мянган төгрөгийг олгохдоо авлага үүсгээгүй орлогоор хүлээн зөвшөөрснийг залруулав.
4. Бараа материалын дансанд бүртгэлтэй 3981.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг холбогдох шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэж залруулав.
5. Эхний хагас жилийн байдлаар 1905.2 мянган төгрөгийн бараа материалыг нярав орлогод авахдаа материал хүлээж авсан өдрөөр бус хэд хоногийн дараа орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснийг орлого орсон тухайн өдрөөр бүртгэж залруулсан.
6. Хагас жилийн тооллогын баримт бичгийн бүрдэл дутууг бүрэн бүрдүүлэн ажилласан байна.
7. СХЗГ-аас 500.0 мянган төгрөгийн НБББББ-ийг орлогоор хүлээн зөвшөөрөөгүйг залруулж орлогоор бүртгэв.
8. Тайлант хугацаанд ХХОАТ-аас чөлөөлөгдөх албан хаагчийн татварын дүнг суутгалгүй шилжүүлсэн, 1270.5 мянган төгрөгийн авлага өглөгөөр тусгаагүй байсныг тайланд тусгуулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 4000.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 4000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацааны эцэст цалингийн зардлаас 2405.0, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 1595.0 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” заалт, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 4374.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Өглөг, авлагын данстай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт: Тайлант хугацаанд 1542.8 мянган төгрөгийн авлага, 1270.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй

1.2.Эрсдэл: Дотоод хяналт сулрах,

1.3.Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч байна. Цаашид анхааран ажиллах

2.Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тушаалаар нийт 1126.7 мянган төгрөгийн шагналыг цалингийн зардлаас олгосон байна

2.2. Эрсдэл: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох, дотоод хяналт сулрах

2.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 5 дугаар тогтоолыг үндэслэх, Сангийн сайдын 2014 оны 55, 2015 оны 7 дугаар журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна

3.Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 390 дугаар тогтоолын дагуу жишиг нормоос нийт 434.3 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулжээ.

3.2. Эрсдэл: Хууль журам зөрчигдөх, үргүй зардал гарах

3.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 390 дугаар тогтоолын дагуу жишиг нормыг баримталж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч байна. Цаашид анхааран ажиллах

4.Шилэн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 3 удаагийн мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

4.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, хариуцлага хүлээх

4.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.2.4, 6.4.7, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.1.6, 2.2.2.3, 2.2.3.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч байна. Цаашид анхааран ажиллах

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

A handwritten signature in blue ink, likely belonging to the auditor mentioned in the adjacent text.

А.СУВДАА